



НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГУУДАД

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Ц.Жигжиджавын гудамж-9,
Нийслэлийн засаг захиргааны II байр
Хангарди ордон
Утас: 33-08-11, Факс: (976-11) 33-08-14
<http://www.it.ub.gov.mn>

2015. 11. 18 № 02/692
танай _____ -ны № _____ -т

Хүсэлт гаргах тухай

Нийслэлийн Мэдээллийн технологийн газар байгуулагдсаны арван жилийн ойн хүрээнд спортын 5 төрөлт тэмцээнийг нийт нутгийн захиргааны байгууллага болон харьяа байгууллагуудын мэдээлэл технологийн мэргэжилтнүүдийн дунд спорт тэмцээн зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Энэхүү арга хэмжээ нь нийт нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийн бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олныг төлөвшүүлэх болон мэргэжил нэгт нөхөдтэйгөө танилцах, хамтран ажиллах нөхцөлийг бүрүүлэхэд оршино.

Иймээс та бүхнийг 2015 оны 11-р сарын 27, 28-ны өдрүүдэд нийт мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг тус тэмцээнд өргөнөөр оролцуулах талаар хамтран ажиллана уу.

Тэмцээнд оролцуулах нийт мэргэжилтнүүдийн талаарх мэдээллийг 2015 оны 11 сарын 24-ны дотор сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Түмэнбаяр /и-мэйл: tumenbayar.b@ulaanbaatar.mn ; Утас: 99187892/ холбогдон мэдэгдэнэ үү.

Хавсралт хуудастай

ОРЛОГЧ ДАРГА  З.БАДРАЛ



Нийслэлийн мэдээллийн технологийн газрын арван жилийн ойг угтан Мэдээлэл технологийн мэргэжилтэнгүүдийн дунд зохион явуулах спортын 5 төрөлт бооцоот тэмцээний удирдамж

Нийслэлийн мэдээллийн технологийн газрын арван жилийн ойг тохиолдуулан мэдээллийн технологийн мэргэжилтэн, албан хаагчдын спортын ур чадварыг сорих зорилгоор спортын 5 төрөлт бооцоот тэмцээнийг зохион байгуулж байна.

Нэг: Зорилго

Тэмцээн нь ажилтан, албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олныг төлөвшүүлэх болон мэргэжил нэгт нөхөдтэйгөө танилцах, хамтран ажиллах нөхцлийг бүрүүлэхэд оршино.

Хоёр: Хамрах хүрээ:

- ✓ Нийслэлийн нутгийн захиргааны удирдах байгууллагуудын мэдээллийн технологийн ажилтангууд
- ✓ Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын мэдээллийн технологийн ажилтангууд
- ✓ Нийслэлийн харьяа байгууллагын мэдээллийн технологийн ажилтангууд
- ✓ Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын мэдээллийн технологийн ажилтангууд

Тайлбар: Мэдээллийн технологийн мэргэжилтэнгүүд нь байгууллага харгалзахгүй нэг баг болох ба эрэгтэй, эмэгтэй гишүүдийн тоог харгалзан тэнцүү хуваагдана.

Гурав: Тэмцээн явагдах хугацаа

Дартс: 2015 оны 11 сарын 27

Цахим тоглоом (CS): 2015 оны 11 сарын 27

Сагсан бөмбөг: 2015 оны 11 сарын 28

Ширээний теннис: 2015 оны 11 сарын 28

Олс татах: 2015 оны 11 сарын 28

Дөрөв: Спортын тэмцээний төрөл, оролцох бүрэлдэхүүн:

№	Спортын төрөл	Тамирчдын тоо	Хүний тоо	Багийн бооцоо
1	Сагсан бөмбөг	4 эр 1 эм	8	Оролцох баг тус бүр 100,000 төгрөг
2	Ширээний теннис	1 эр 1 эм	8	
3	Олс татах	Баг	8	
4	Цахим тоглоом	Баг	8	
5	Дартс	1 эр 1 эм	8	

Техникийн зөвлөгөөн 2015 оны 11 сарын 26-нд 16:30 цагаас Мэдээллийн технологийн газар 7 давхар 704 тоот хурлын танхимд болно.

Тав: Шагнал урамшуулал

Нийт оролцсон баг тус бүрийн бооцоог нэгтгэн шагналын санг бүрдүүлнэ.

Багийн дүнгээр нэгдүгээр байр:

1-р байр нэг өргөмжлөл, мөнгөн шагнал | Бооцооны 60%

2-р байр нэг өргөмжлөл, мөнгөн шагнал | Бооцооны 30%

3-р байр нэг өргөмжлөл, мөнгөн шагнал | Бооцооны 10%

Багийн дүнг тооцоход тэмцээний чанарын оноог тооцно:

Сагсан бөмбөг:

- 1-р байр 40 оноо
- 2-р байр 30 оноо
- 3-р байр 20 оноо

Ширээний теннис:

- 1-р байр 10 оноо
- 2-р байр 7 оноо
- 3-р байр 4 оноо

Олс татах:

- 1-р байр 10 оноо
- 2-р байр 7 оноо
- 3-р байр 4 оноо

Цахим тоглоом:

- 1-р байр 30 оноо
- 2-р байр 20 оноо
- 3-р байр 10 оноо

Дартс:

- 1-р байр 10 оноо
- 2-р байр 7 оноо
- 3-р байр 4 оноо

Жич:

- ✓ Багуудын оноолтыг тухайн өдөр сугалаа сугалж шийдвэрлэнэ.
- ✓ Тэмцээнийг оролцох багийн тооноос хамаарч зоонд хуваана. 1 зооноос 2 баг дараагийн шатанд буюу хагас шигшээд шалгарна. Хагас шигшээд шалгарсан багууд аваргын төлөө тоглох эрхээ авна.
- ✓ Тэмцээнд оролцох багуудын хувцас жигдэрсэн, хувийн дугаартай байх.
- ✓ Тэмцээнд оролцохдоо ажилтан нь ажлын газрын үнэмлэх авчрах ба мэдээллийн технологийн ажилтан байна.
- ✓ Багийн бооцоог авч ирнэ
- ✓ Тэмцээнд оролцогч багийн бүрэлдэхүүнд гаднаас тамирчин оруулахгүй бөгөөд оруулахыг завдсан тохиолдолд шууд хасаж багийн оноог 0 болгоно.
- ✓ Тухайн баг тоглолтын хуваарийн дагуу цагтаа ирээгүй тохиолдолд тухайн тоглолтыг хожигдсонд тооцно.
- ✓ Тэмцээн өглөө 9 цаг 00 минутанд эхлэнэ.
- ✓ Багуудын мэдүүлгийг бооцооны хамт 2015 оны 11 сарын 26-ний дотор НМТГ-ийн 7 давхарт 704 тоот өрөөнд хүлээн авах бөгөөд оролцогчид мэдүүлэг дээр зургаа наасан байна.

Харилцах утас: 11330844, 99187892, 96077007, 99910989, 88087686

И-мэйл: tumenbayar.b@ulaanbaatar.mn

Зохион байгуулагч: **Нийслэлийн мэдээллийн технологийн газар**